



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 09 өдөр

Дугаар A/106

Жаргалтхаан

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг, сумын аварга шалгаруулах Адуучин тэмцээнийг зохион байгуулахад зориулж 3,000,000 (гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд зарцуулагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, Нягтлан бодогч Э.Загдхүү нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (С.Ганбат)-д даалгасугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

232401265